

Савласан эрдэст усны чанар

Байгаль дээр тохиолдож байгаа ус болгон өөр өөрийн чанар, найрлагатай учраас тэр бүр хүний эрүүл мэндэд тохирдоггүй, зохих түвшинд боловсруулалт хийж хэрэглэдэг. Гэвч ус болгоныг ижил технологиор боловсруулах албагүй, чанар найрлагаас нь хамааруулж өөрийн технологийн сонголт хийх учиртай.

Эрдэст ус гэдэг маань нэрсэн ус шиг бүх элементүүдийг нь арилгасан усыг хэлж байгаа хэрэг биш юм. Судалгаанаас үзэхэд усанд байх нийт эрдэсжилтийн хэмжээ $150-350 \text{ мг/дм}^3$ орчим байх нь хамгийн тохиромжтой гэж тооцдог. Эрдэст усанд макро (кальци, магни, кали, натри, хлорид) болон микро (төмөр, цайр, иод, манган, селен, фтор, цахиур) элементүүд агуулах бөгөөд эдгээр элементүүдээр баялаг тул хүний бие махбодод тустай юм. Эрдэст усыг тогтмол хэрэглэснээр ходоод, гэдэсний өвчнөөс урьдчилан сэргийлж, хүчил, шүлтийн тэнцвэрийг хангах, хумс, үсийг бэхжүүлдэг байна.

Эрүүл амьдрахын үндэс нь эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй, найдвартай ус гэж үздэг. Өнөө үед хүн амын дунд олон хүчин зүйлээс шалтгалан савласан ус, тэр дундаас эрдэст усны хэрэглээ нэмэгдэж байна. Улсын хэмжээгээр хамгийн их борлуулагддаг нарийн боов, талхны араас цэвэр ус бичигддэг байна. Одоогоор улсын хэмжээнд савласан усны 90 үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, “Жем хужирт” компанийн “Хужирт” ус нийт цэвэр ус үйлдвэрлэлийн зах зээлийн 7%-ийг эзэлж байна.

Манай оронд ихэвчлэн гүний цэвэр усыг шүүж, цэвэршүүлэн савлаж худалдаалдаг. Савласан усны эрүүл ахуй, чанар, аюулгүй байдал нь үйлдвэрлэлийн стандарт болон шалгуур үзүүлэлтүүдээр хяналтанд орж, савлагаа нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангасан байх шаардлагатай байдаг. Савласан ус нь хэд хэдэн төрлөөр ангилагддаг. Үүнд:

1. Байгалийн эх үүсвэрийн ус- Гол горхи, худаг, булаг зэрэг байгалийн цэвэр усны эх үүсвэрээс авдаг ба химийн нэмэлт бодисгүй байдаг.
2. Цэвэршүүлсэн ус - Энэ нь хотын усан хангамжаас авч, нэмэлт шүүлтүүр болон цэвэршүүлэх процессоор ариутгасан ус юм.
3. Эрдэсжүүлсэн ус - Энэхүү усанд бие организмд хэрэгтэй эрдэс бодисуудыг нэмдэг бөгөөд зарим тохиолдолд байгалийн эрдэсжүүлэлтэй байдаг.
4. Хийжүүлсэн ус - Хүчилтөрөгчөөр баяжуулсан эсвэл нүүрсхүчлийн хийгээр хийжүүлсэн ус юм.



Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгийн усны лаборатори нь манай орны зах зээлд худалдаалагдаж байгаа 4 савласан цэвэр усанд хүчил шүлтийн тэнцвэр хангаж байгаа эсэхэд лабораторийн шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүнгээр Хужирт, Тэрэлж, Aqua-Se, Millenia зэрэг савлсан цэвэр ус нь хүний биед шаардлагатай эрдэс давсыг зохих хэмжээгээр агуулж байгаа бөгөөд шошгон дээрх элементүүдийн тоон үзүүлэлтүүд нь дээрх стандартаас зөрсөн зөрүүгүй байна. Монгол улсад мөрдөгдөж байгаа “Савласан ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 5007:2022” стандартын “Эрдэслэг цэвэр ус”-ны шаардлага хангасан байна.

ЭШДаА, С.Эрдэнэчимэг
 ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн
 Усны нөөц, ус ашиглалтын салбар